



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

*MONTHLY BULLETIN OF STATISTICS*

2018/10



[www.nso.mn](http://www.nso.mn) [govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)



## ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд .....
- IV. Гэмт хэрэг .....
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй .....
- VIII. Аж үйлдвэр .....
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



**I. Нийгмийн байдал**


**I.1 Ажил хайгч иргэд**

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 217, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 154 байгаагийн 91 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 63 буюу 22.5 хувиар, өмнөх сараас 29 буюу 11.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аравдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 83 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 63 иргэн ажилд зуучлагдсаны 30 буюу 47.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн болно.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 25, 25-34 насны 65, 35-44 насны 30, 45-54 насны 28, 55 түүнээс дээш насны 6 иргэн байна.

**I.2 Ердийн хөдөлгөөн**


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 10 сарын байдлаар 392 эх амаржиж, 393 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 74 буюу 23.3 хувиар, төрсөн хүүхдийн тоо 69 буюу 21.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Нас баралт 73, бүртгүүлсэн гэр бүл 73, цуцалсан гэр бүл 15 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 9 буюу 37.5 хувиар, нас баралт 11 буюу 13.1 хувиар буурч, бүртгүүлсэн гэр бүл 13 буюу 21.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 6 хүүхэд үрчлэгдсэн.



Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 495 хүн шилжин ирж, 439 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт ижил түвшинд, шилжин явалт 13.4 хувиар нэмэгджээ.

Зураг 1.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



## II. Нийгмийн даатгал, халамж

### II.1 Нийгмийн даатгал

2018 оны эхний 10 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 8481.2 сая төгрөг, зарлага 8776.9 сая төгрөг болсон байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 130.7 хувьтай, зарлагын гүйцэтгэл 99.3 хувьтай байна.

### II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 10 сарын байдлаар 6410 хүнд 1642.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 2154 хүн буюу 50.6 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 508.2 сая төгрөг буюу 44.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2018 оны эхний 10 сарын байдлаар 2134 хүн хамруулж 986.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 948 хүн буюу 79.9 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 400.0 сая төгрөг буюу 68.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2018 оны эхний 10 сарын байдлаар 4276 хүн хамруулж 655.7 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1206 хүн буюу 39.3 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 108.2 сая төгрөг буюу 19.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


### II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 10 дугаар сарын мэдээгээр 208 байгууллагын 5587 даатгуулагч иргэн, үүнээс 615 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 425



даатгуулагчийн дундаж цалин 630.1 мянган төгрөг, төсөвт 54 байгууллагын 1756 даатгуулагчийн дундаж цалин 627.3 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 659 даатгуулагчийн дундаж цалин 1092.9 мянган төгрөг, 122 ХХКомпаний 1963 даатгуулагчийн дундаж цалин 735.9 мянган төгрөг, бусад 19 аж ахуйн нэгж байгууллагын 169 даатгуулагчийн дундаж цалин 350.2 мянган төгрөг боллоо.

Зураг II.1.Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2018 оны эхний 10 сарын байдлаар




### III.Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2018 оны эхний 10 сарын байдлаар 396 эх амаржиж, 2017 оны мөн үетэй харьцуулахад 51 буюу 14.8 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 345 үүнээс 200 нь хүү, 195 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 49 буюу 14.2 хувиар нэмэгдсэн байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2 бүртгэгдсэн байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар





Халдварт өвчин эхний 10 сарын байдлаар 214 буюу 10000 хүн амд 122.9 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 53 тохиолдлоор өссөн байна.


Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 92407 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3206 хүнээр буюу 3.6 хувиар, 4246 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 329 хүнээр буюу 8.4 хувиар нэмэгдсэн байна.

2018 оны эхний 10 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 5211, халдварт өвчин 214 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар






#### IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 10 сарын байдлаар 138 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14 буюу 9.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тодорхой хэмжээгээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 53 байгаа нь өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 60.2 болсон нь өмнөх оны мөн үеэс 6.2 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 86 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 10 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны эхний 10 сарын байдлаар 535.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 234.7 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 256.7 сая төгрөгөөр буюу 1.9 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 39.9 сая төгрөг буюу 20.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны эхний 10 сарын байдлаар давхардсан тоогоор 583 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13 хүнээр буюу 2.3 хувиар өссөн байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 10 сарын байдлаар



#### V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2018 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, 2018 оны жилийн эцсээс 5.3 хувиар, өмнөх сараас 1.4 хувиар өсч байна.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 10 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2018.X}{2017.X}$	$\frac{2018.X}{2017.XII}$	$\frac{2018.X}{2018.IX}$
Ерөнхий индекс	105.2	105.3	101.4
Хүнсний бараа, ундаа, ус	106.9	108.1	101.9
Согтууруулах ундаа, тамхи	108.9	107.2	100.2
Хувцас, бөс бараа, гутал	101.6	100.9	100.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.4	103.4	101.3
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	107.4	107.6	102.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	100.7	100.7	100.5
Тээвэр	109.1	109.1	101.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.1	100.1	100.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	118.3	120.0	103.2
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	110.0	110.0	104.1
Бусад бараа, үйлчилгээ	105.6	104.4	102.1

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ




**VI. Төсөв санхүү**

2018 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 18651.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 16977.4 сая төгрөг болж 91.0 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 14721.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 11882.2 сая төгрөг болж 80.7 хувийн гүйцэтгэлтэй байна.


2018 оны эхний 10 сарын байдлаар авлагын үлдэгдэл 66.2 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 99.8 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй, газар тариалан**


Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 201476 хээлтэгч малын 141843 буюу 70.4 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 84.9 хувьтай байна. 2018 оны эхний 10 сарын байдлаар 30675 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 14.0 дахин их байна. Том малын зүй бус хорогдлын 20.2 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1. Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, толгойгоор






Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, толгойгоор



2018 онд аймгийн хэмжээнд нийт 40.91 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 1.24 га талбайгаар буюу 7.2 хувиар, хүнсний ногоо 4.26 га талбайгаар буюу 24.7 хувиар буурч, тэжээлийн ургамал 7.7 га талбайгаар буюу 2.8 дахин нэмэгдсэн байна.


Зураг VII.3.Тариалсан талбай, 2017, 2018 оны байдлаар, га



10 дугаар сарын ургац хураалтын мэдээгээр аймгийн хэмжээнд 15.2 га талбайгаас 95.8 тн төмс, 12.9 га талбайгаас 130.7 тн хүнсний ногоо, 7.0 га талбайгаас 66.7 тн тэжээлийн ургамал хураасан нь өмнөх оны мөн үеэс, тэжээлийн ургамал 53.6 хувиар их, төмс хураалт 4.8 хувиар, хүнсний ногоо 7.1 хувиар бага байна.



Зураг VII.4.Хураасан ургац, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, тн



### VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2018 оны эхний 10 сарын байдлаар 37.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөг буюу 4.7 хувиар, оны үнээр 40.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.5 тэрбум төгрөг буюу 0.9 хувиар буурсан байна.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 95.1 хувь буюу 36.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 95.7 хувь буюу 39.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1.Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр





## IX. Цаг агаарын мэдээ 10 дугаар сард:

Хур тундас: 9, 25-ны өдрүүдэд хур тунадас орж, нийт 0,0 мм тунадастай.

Салхи: Энэ сард ихэнхи хугацаанд салхи 4-9 м/сек, зарим үед 3-7, 21, 22, 24-28-ны өдрүүдэд 11-18 м/сек хүрч ширүүссэн.

Агаарын температур: Агаарын температур 1-р арав хоногийн эхээр 2-р арав хоногт шөнөдөө 4 градус хүйтнээс 1 градус дулаан, өдөртөө 14-19 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 9-12 градус дулаан байсан байна.



### 2018 оны 11 дүгээр сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж нь Говьсүмбэр аймгийн нутгаар 6-11 градус хүйтэн байдаг ба ихэнх нутгаар уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн ихэнх хугацаанд шөнөдөө 9-14 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр бага зэрэг хүйтэрнэ. Хоёрдугаар арав хоногийн сүүлийн хагаст шөнөдөө 15-20 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн байна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн шөнөдөө 20-25 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь уур амьсгалын дунджийн орчим орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн эхээр 12-14 м/с, нэгдүгээр арав хоногийн дунд үе ба сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.





## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	346	395	114.2
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	185	154	83.2
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	161	214	132.9
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	152	138	90.8
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	12251.3	16977.4	138.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	11400.9	11882.2	104.2
Авлага	сая.төг	8.3	66.2	7 дахин
Өглөг	сая.төг	79.4	99.8	125.7
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	39799.4	37924.6	95.3
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	41160.3	40762.0	99.0
Төллөсөн хээлтэгч	толгой	141527	141843	100.2
Гарсан төл	толгой	142340	142803	100.3
Хорогдсон төл	толгой	1425	21605	1516.1
Бойжсон төл	толгой	140915	121198	86.0
Том малын зүй бусын хорогдол	толгой	2195	30675	1397.5



## I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 X	2018 X	$\frac{2018 X}{2017 X} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	280	217	77.5
Үүнээс: эмэгтэй	178	129	72.5
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	185	154	83.2
Үүнээс: эмэгтэй	111	91	82.0
Ажлын байрны захиалга	33	83	251.5
Ажилд зуучлагдсан иргэд	21	63	300.0
Үүнээс: эмэгтэй	4	30	750.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

## I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Амаржсан эх	318	392	123.3
Төрсөн хүүхэд	324	393	121.3
Үрчлэгдсэн хүүхэд	2	6	300.0
Бүртгүүлсэн гэр бүл	60	73	121.7
Цуцалсан гэр бүл	24	15	62.5
Нас баралт	84	73	86.9
Шилжин ирсэн	495	495	100.0
Шилжин явсан	387	439	113.4

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

## II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сангийн төрөл	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	7 193.2	8 481.2	117.9
НД-ын сангийн зарлага, сая.төг	8 974.9	8 776.9	97.8

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



## II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-X		2018 I-X		$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	4 256	1 133.9	6 410	1 642.1	150.6	144.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 186	586.4	2 134	986.4	179.9	168.2
Халамжийн тэтгэвэр	264	318.9	251	344.8	95.1	108.1
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	922	267.5	1 883	641.6	204.2	239.9
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	3 070	547.5	4 276	655.7	139.3	119.8
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	987	175.6	1 738	210.7	176.1	120.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	222	47.2	271	49.1	122.1	104.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ	379	35.7	697	79.5	183.9	283.5
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	250	111.9	294	139.0	55.6	124.2
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5	10.0	6	8.7	120.0	87.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 227	167.0	1 270	168.7	103.7	103.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



## III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Төрсөн эх	345	396	114.8
Амьд төрсөн хүүхэд	346	395	114.2
Эрэгтэй	185	200	108.1
Эмэгтэй	161	195	121.1
Амьгүй төрсөн хүүхэд	2	1	50.0
Нийт нас баралт	70	54	77.1
Эмнэлгийн нас баралт	5	9	180.0
Хоног болоогүй нас баралт	5	3	60.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	1	50.0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	2	66.7
Эмчлэгдсэн өвчтөн	3 917	4 246	108.4
Амбулаторийн үзлэг	89 201	92 407	103.6
Халдварт өвчин	161	214	132.9

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

## IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 10 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	152	138	90.8
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	76	76	100.0
Өмчлөх эрхийн эсрэг	53	39	73.6
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	3	3	100.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14	12	85.7
Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	2	50.0
Авилгын эсрэг гэмт хэрэг	0	5	*
Бусад гэмт хэрэг	2	1	50.0





Гэмт хэрэгт <u>холбогдог</u> сод	154	96	62.3
15 хүртэлх насны	6	1	16.7
16-34 насны	92	56	60.9
35 ба түүнээс дээш насны	56	39	69.4
Боловсрол – Дээд	29	19	65.5
Боловсрол - Тусгай дунд	6	8	133.3
Боловсрол – Бүрэн дунд	45	32	71.1
Боловсрол – Бүрэн бус дунд	42	22	52.4
Боловсрол – Бага	13	8	61.5
Боловсролгүй	19	7	36.8
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	11	23	209.1
Ажилгүй иргэд үйлдсэн	67	54	80.6
Эмэгтэй хүн оролцсон	22	13	59.1
Хүүхэд оролцсон	15	4	26.7
Бүлгээр үйлдсэн	12	8	66.7
Согтуугаар үйлдсэн	45	58	128.9
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	152	138	90.8
Гудамж талбайд	45	40	88.9
<u>Гэмт хэргийн</u> улмаас нас барсан	9	5	55.6
<u>Гэмт хэргийн</u> улмаас гэмтсэн	103	86	83.5
Учирсан хохирол / сая.төг /	278.0	535.0	192.4
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	195.0	234.7	120.6

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

#### VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Нийт орлого	12 251.3	16 977.4	138.5
Урсгал орлого	4 734.6	4 259.3	89.9
Татварын орлого	3 610.8	3 854.5	106.7
Татварын бус орлого	1 123.9	404.8	36.0
Тусламжийн орлого	7 516.7	12 718.1	169.2

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



## VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Нийт зарлага	11 400.9	11 882.2	104.2
Урсгал зардал	10 023.4	10 865.9	108.4
Хөрөнгийн зардал	1 377.5	1 016.3	73.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

## VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Авлага	8.3	66.2	7 дахин
Өглөг	79.4	99.8	125.6
Төсөвт байгууллагын тоо	49	49	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

## VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Бүгд	141 527	141 843	100.2
Ингэ	120	140	116.7
Гүү	4 305	2 984	69.3
Үнээ	3 984	3 361	84.4
Эм хонь	69 113	71 775	103.9
Эм ямаа	64 005	63 583	99.3

## VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Дүн	141 527	141 843	100.2
<u>Баянтал</u>	21 720	26 374	121.4
Сүмбэр	102 643	98 673	96.1
<u>Шивээговь</u>	17 164	16 796	97.9



## VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Бүгд	140 915	121 198	86.0
Ботго	116	134	115.5
Унага	4 286	2 776	64.8
Тугал	3 952	3 143	79.5
Хурга	68 817	63 687	92.5
Ишиг	63 744	51 458	80.7

## VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Дүн	140 915	121 198	86.0
<u>Баянтал</u>	21 801	25 117	115.2
Сүмбэр	101 896	78 910	77.4
<u>Шивээговь</u>	17 218	17 171	99.7

## VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Бүгд	2 195	30 675	1 397.5
Тэмээ	3	7	233.3
Адуу	30	1 151	503.3
Үхэр	105	1 615	1 538.1
Хонь	814	11 289	1 386.9
Ямаа	1 243	16 613	1 336.5

## VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Дүн	2 195	30 675	1 397.5
<u>Баянтал</u>	274	2 250	821.2
Сүмбэр	1 838	27 948	1 520.6
<u>Шивээговь</u>	83	477	574.7



## VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Бүгд	432	6 369	1 474.3
Тэмээ	0	1	*
Адуу	7	291	4 157.1
Үхэр	27	335	1 240.7
Хонь	210	2 130	1 014.3
Ямаа	188	3 612	1 921.3

## VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Дүн	432	6 369	1 474.3
<u>Баянтал</u>	34	366	1 076.5
<u>Сүмбэр</u>	377	5 878	1 559.2
<u>Шивээговь</u>	21	125	595.2

## VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Нийт	39 799.4	37 924.6	95.3
Нүүрс олборлолт	35 607.4	36 071.0	101.3
Боловсруулах үйлдвэр	2481.6	96.3	3.9
Цахилгаан,дулааны эрчим хүч	1 710.3	1 757.4	102.7

## VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I-X}{2017 I-X} \%$
Нийт	41 160.3	40 762.0	99.0
Нүүрс борлуулалт	37 297.5	39 045.4	104.7
Боловсруулах үйлдвэр	2 293.7	84.1	3.7
Цахилгаан, дулаан эрчим хүч	1 569.0	1 632.4	104.0



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	$\frac{2018 I - X}{2017 I - X} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	37 297.5	39 045.4	104.7
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	35 607.4	36 071.0	101.3
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	1 575.8	1357.3	86.1
Ажиллагсад	556	536	96.4

Е-майл хаяг:

[govisumber@nso.mn](mailto:govisumber@nso.mn)

Вэб хаяг:

[govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn)

Мэдээллийн сангийн хаяг:

[www.1212.mn](http://www.1212.mn)

Утас:

70543222, 70543017